

Ю.Атар доктор (Ph.D)
МУБИС-ийн Нийгмийн Ухааны тэнхимийн багш

Улс төрийн системийн бүтцийн өөрчлөлтөнд нөлөөлөх хүчин зүйлүүд

Өгүүллийн товч утга: Улс төрийн системийн бүтэц тэдгээрийн хоорондын харилцан хамаарал, улс төрийн системийн өөрчлөлтөд нөлөөлөх хүчин зүйлүүдийг шинжлэн гаргахыг эрмэлзэв.

Түлхүүр үг: улс төрийн систем, улс төрийн орчин, улс төрийн хямрал, үндсэн хуулийн зохицуулалт, улс төрийн үйл явцын нөлөөлөл, улс төрийн соёлын нөлөөлөл

Аливаа эрх зүйт улс төрийн системийн бүтэц нь тухайн орны үндсэн хуулиар тодорхойлогддог. Аливаа улс орны үндсэн хууль нь тус улсын бүрэн эрхт байдал, хүний эрх, эрх чөлөө, улс төрийн системийн бүтэц, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага, үндсэн хуульд нэмэлт ба өөрчлөлт оруулах механизм зэргээс бүрддэг. Үндсэн хууль нь бусад бүх эрх зүйн дээд хэлбэр бөгөөд аливаа улс орон үндсэн хуульдаа зохицуулан үндсэн хуульчилсан бэлэн салбар эрх зүйг зохиож нийгмийн системийг зохицуулдаг.

Энэ зохицуулалтын хамгийн гол механизм нь улс төрийн системийн бүтэц юм. Улс төрийн системийн бүтцийг засаглал хуваарилах онолын үндсэн дээр харилцан тэнцвэртэй зохион байгуулдаг бөгөөд хэрэв тэнцвэр алдагдсан нөхцөлд улс төрийн системийн бүтцэд болон нийгэмд гажуудал гардаг¹ гэж тэмдэглэсэн байдаг. Улс төрийн системийн бүтэц нь засаглалын эрх мэдэл үүргийн хуваарилалтанд хяналт, тэнцвэржүүлэлт шаардлагатай юм.

Парламентын засаглалтай оронд хууль тогтоох байгууллага нь төрийн үүрэг гүйцэтгэдэг учраас харьцангуй их эрх мэдэл, хариуцлагатай бөгөөд өндөр хэмжээнд бэлтгэгдсэн боловсон хүчинээр хангагдсан байх нь зохимжтой. Харин ерөнхийлөгчийн засаглалтай оронд парламент нь хууль тогтоох гол үүрэгтэй бол парламентын засаглалтай оронд парламент нь хууль тогтоох, төрийн үүрэг гүйцэтгэх, давхар хяналт тогтоох гол чиг үүрэгтэй байдгаараа асар их ялгаатай. Тэгвэл гүйцэтгэх засаглал нь парламентын засаглалтай оронд хууль тогтоох засаглалын хяналт, хүрээн доор (батламжаар) зохион байгуулагддаг.

Гүйцэтгэх засаглалын хүрээнд асуудал шийдвэрлэхэд нэг хүнд эрх мэдэл төвлөрөх явдал байдаг бөгөөд үүнийг шуурхай гүйцэтгэл хариуцлагын асуудалтай холбож зөвтгөдөг бөгөөд эрх мэдэл нь байнга сөрөг үр дагавар төрүүлдэг. Тэгвэл энэ гүйцэтгэх эрх мэдлийг тойрон хүссэн хүсээгүй авилгал зохион байгуулалттай гэм хэрэг (мафи) зэрэг бүх л сөрөг үзэгдлүүд дагадаг нь философийн зүй тогтолтой юм. Энэ нь гүйцэтгэх засаглалын доод түвшинд ч эрх мэдэл хуваарилах шаардлагатайг харуулж байна. Учир нь манай хуучин тогтолцооны үед авилгал, зохион байгуулалттай гэмт хэрэг (ХОТШ банкны 3.5 тэрбум төгрөг ба Монсан ХХК) харьцангуй бага буюу бараг үгүй байсан нь дарга, ҮХД, намын дарга, АХШХ гэх мэт эрх мэдлийн хуваарилалт, хяналт өндөр байсантай холбоотой. Үүнээс үндэслээд эрх мэдэл бүхий албан тушаалын дэргэд янз бүрийн улс төрийн хүчинүүдийн хяналтын маягийн албан тушаал байж болох юм. Ер нь эрүүл саруул удирдлага ба эдийн засаг байж гэмээн улс орнууд хөгжлийн өндөр түвшинд хүрнэ. Жишээлбэл, Улс төрийн системийн оршин тогтоох эх сурвалж эдийн засгийн үндэс болсон татварын

¹ Юндэндорж А., Атар Ю. Өрнө дорнын мэргэдийн нийгэм-улс төрийн онол, сургаал. Дэд, гутгаар дэвтэр, Хөх хот, 2003, 103-105 дахь талууд.

бодлого боловсронгуй бишээс татвар төлөхгүй байх, нуух, хэтрүүлэн төлж хэлмэгдэх зэрэг олон сөрөг үр дагавар гардаг. Татварын бодлогод шинжлэх ухааны үндэстэй нарийн судалгаа хийж, харьцангуй уян хатан боломжтой нөхцлөөр тогтоож, зөв зохион байгуулвал ийм явдал гарагч. Учир нь нэг талаас татвар авагчид гэж юу л байна авах гэдэг аймшигт мангас, нөгөө талаас өгөхгүй байх хүсэл эрмэлзэл бултан зугтах, нуун дарагдуулах үзэгдлээр дан ганц тайлбарлаж болохгүй.

Улс оронд татварын орлого нэмэгдэх нь иргэдэд хүнд суртал албадлагын элдэв бэрхшээлгүй тэдгээр хүмүүсийн гарцаагүй зардлын тооцоонд ороод явдаг хэвшсэн зүйл болох юм. Гэвч ингэж зохион байгуулах нь эрх мэдэл авсан хүмүүс буюу албан тушаалтнуудад болон тухайн аппаратад ажиллагсадын хэд хэдэн сонирхлын улмаас зохион байгуулахыг хүсээгүйтэй холбоотой юм. Үүнд:

1. Эрх мэдэл нэг хүн буюу нэг хэсэг хүний мэдэлд шилжсэнээр авилгал өгөх, авах эх үүсвэр бий болсон.
2. Дарга удирдагчид нь авилгалаар шийдвэр гаргаж байгаа нь ажиллагсадад нөлөөлнө. Тэд мөн өөрийн бяцхан эрх хэмжээнд авилгал өгөх, авах боломж бүрдүүлэхийг хичээнээр ажлын хариуцлага, ажлын ямар ч зохион байгуулалтгүй болно. Ингэснээр хүнд суртал, чирэгдүүлэл, хэлмэгдүүлэл үүснэ.
3. Авилгал өгч авдагийг үйлчлүүлэгчид мэдэж ойлгодог болсон учраас татвар төлөхөөс цааргалах, боломж олдвол авилгал өгөхийг хичээх болно.
4. Авилгал нь авилгал өгөгчдөө эдийн засгийн хувьд татвар төлөхөөс ашигтай байдаг ба авилгал цалингаас гадуур орлого олох эх үүсвэр болдог учраас тэд энэ замыг хэзээ ч хаахгүй. Зөвхөн шударга хүн болж жүжиглэн татвар төлөгч гэмгүй хүмүүсийг хэлмэгдүүлнэ.
5. Энэ бүхэн нийт ард түмэн, үйлчлүүлэгчид, татвар төлөгчдөд ойлгомжтой бөгөөд үйлдэл дээр нь барьсан баримтгүй бол ямар ч ял зэмлэлгүй учраас тэд яаж ч чадахгүй болохоор татвар төлөхөөс эрс татгалзаж цааргалах эх үндэс суурь болно.

Энэ бүхэн нь хууль эрх зүйг сахин биелүүлэх болон ёс суртахууны хэмжүүр алдагдахад хүргэнэ. Төрд итгэх иргэдийн итгэл алдрах, нийгмийн оюун санаа хямрахад нөлөөлөн асуудал зөвхөн гүнзгийрсэн буюу улс төр, эдийн засгийн хямрал туйлдаа хүрсэн нөхцөлд улс төрийн системийн бүтэц ч бус улс төрийн системийг ч өөрчлөхөд хүрч болно.

Улс төрийн системийн бүтцэд нөлөөлөх хүчин зүйлүүдийг доорх ангиллаар авч үзэж болох байна. Үүнд:

1. Улс төрийн хямрал
2. Эдийн засгийн хямрал
3. Улс төрийн системийн орчин
4. Нийгмийн улс төрийн соёл
5. Улс төрийн үйл явц (дэмжлэг, шаардлага)
6. Улс төрийн намууд
7. Сонирхлын болон шахалтын бүлэг
8. Орон нутгийн удирдлага ба байгаль, экологи, газар зүйн нөлөөлөл
9. Нийгмийн оюун санааны хямрал зэрэг болно.

Улс төрийн хямрал улс төрийн системийн бүтцэд нөлөөлөх нь: Улс төрийн системийн бүтэц дэх засаглалын тэнцвэр алдагдсан нөхцөлд улс төрийн хямрал гарах нь зайлшгүй. Энэ нь ямар нэгэн шийдвэр буюу төрийн хямрал гарах нь зайлшгүй. Энэ нь ямар нэгэн шийдвэр буюу санамсаргүй байдлаар илрэн гарна. Өөрөөр хэлбэл философиийн зайлшгүй санамсаргүйн категоритой адилтгаж үзэж болно. Жишээ нь: Улаан гэрэл байнга зөрчдөг жолооч осолд орох нь зайлшгүй бөгөөд цаг хугацаа нөхцөл байдлын

хувьд санамсаргүйгээр илрэн гардаг. Тэгвэл засаглалын тэнцвэр алдагдсан шийдвэрүүд бүрэн биелэгдэхгүй нь зайлшгүй бөгөөд цаг хугацаа нөхцөл байдал, орон зайн хувьд санамсаргүйгээр илрэн гарна. Улс төрийн систем дэх тэнцвэр алдагдсан нөхцөлд дотоод, гадаад ба хаалттай нээлттэй шаардлагууд эрс нэмэгдснээр улс төрийн хямралд хүргэх буюу бүтцийн өөрчлөлт гарах нөхцөл бий болно.

Улс төрийн орчин улс төрийн системийн бүтцэд нөлөөлөх нь: «Систем» болон «орчин» гэдэг ойлголтууд хоорондоо харилцан уялдаатай диалектик нэгдэл юм. Орчин гэдэг маань системд нөлөөлж буй гадны хучин зүйлийг хэлнэ. Системд нөлөөлдөг орчны маш олон элемент байдаг. Эдгээр нь системд ямар нэгэн хэмжээгээр нөлөө үзүүлдэг. Орчинг өргөн утгаар нь тухайн системийг хүрээлэн буй бүх зүйлийг хэлнэ. Орчинг явцуу утгаар нь тухайн системд зөвхөн өөрт нь хамааралтай тийм хүчин зүйлийг хэлнэ. Ямар ч систем өөрийн эхлэл үедээ хүрээлэн байгаа орчиндоо дарамталж байдаг. Тэр дарамтыг давбал тухайн систем оршин тогтнодог.

Улс төрийн системийн бүтэц хэр зэрэг зохион байгуулалттай байна төдий чинээ орчин тогтвортой байдаг. Нөгөө талаар хэдий чинээ зохион байгуулалттай байна төдий чинээ орчиндоо эмзэг ханддаг. Бас улс төрийн системийн бүтэц хэдий чинээ уян хатан байна төдий чинээ орчноос ирсэн мэдээллийг зөв зохицуулна. Орчноос мэдээлэл бага ирэх тусам улс төрийн систем ба бүтцэд итгэх итгэл алдарна. Улс төрийн системийн бүтцэд итгэх итгэл алдагдснаас улс төрийн системийн бүтэц өөрчлөгдөх үндэс суурь бий болно.

Улс төрийн системийн бүтцэд эдийн засгийн хямрал нөлөөлөх нь: Марксист философид нийгмийн ахуй анхдагч ухамсар хоёрдогч гэж үздэг². Өрнөдийн философчид ухамсын биеэ даасан шинж хүчийг хэтрүүлэн үнэлж шийдвэрлэгч хүчин зүйл гэж үздэг³. Гэвч аливаа юм харьцангуй байдаг. Ертөнцөд дан ганц төгс юм гэж үгүй. Ертөнцийн бүх юм, бүх элемент уялдан зохицож байж төгс төгөлдөр байдаг. Тэгвэл дан ганц үзэл санаа, оюун ухааны зүйл объектив ба субъектив хүчин зүйл буюу эдийн засаг, хүний хүчин зүйлтэй нэгдэхгүйгээр асуудлыг шийдэж чадахгүй. Ингэхээр улс төрийн систем ч эдийн засаггүй оршин тогтнож чадахгүй нь мэдээж хэрэг. Улс төрийн систем ба системийн бүтэц нь үндсэндээ нийгмийн эдийн засгийн асуудлыг улс төрийн аргаар зохицуулдагт оршино. Улс төрийн системийн бүтцэд эдийн засаг хамгийн их нөлөөлдөг хүчин зүйлийн нэг юм. Улс төрийн системийн бүтэц хэдий чинээ сүл дорой, ядуу байна төдий чинээ эдийн засгийн болон бусад орчинтой хутгалддаг. Улс төрийн системийн бүтэц боловсронгуй болох тусам эдийн засгийн болон бусад орчноос хамаарал багатай болно. Улс төрийн системийн бүтэц нь эдийн засгийг зохицуулж чадахгүй бол өөрөө өөрчлөгддэг.

Улс төрийн үйл явц улс төрийн системийн бүтцэд нөлөөлөх нь: Улс төрийн үйл явц буюу үйл ажиллагаа нь зорилго, агуулга, субъект хамарч буй хүрээ зэрэг олон ялгаатай шинж чанартай бөгөөд улс төрийн, эдийн засгийн, олон нийтийн, аж ахуйн гэх мэт олон төрлийн байдаг. Жишээ нь: улс төрийн үйл ажиллагааг улс төрийн зорилгоор нь ангилбал:

1. Улс төрийн байр сууриа илэрхийлэх
2. Тодорхой шийдвэрийг өөрчлөх
3. Засгийн газрыг өөрчлөн байгуулах
4. Парламентыг тараах
5. Улс төрийн системийг өөрчлөх гэх мэтээр ангилж үздэг.

Энэ бүх үйл явц буюу үйл ажиллагаа нь бүгд улс төрийн систем ба улс төрийн системийн бүтцэд ханддаг нь түүний шийдвэр, тогтолцоо гэх мэт олон зүйлээс хамаарна.

² Философская энциклопедия. М., 1983, с.87.

³ Малахов В.С., Филотова В.П. Современная западная философия. М., 1998, с.48.

Улс төрийн соёл улс төрийн системд нөлөөлөх нь: Нийгмийн соёл, улс төрийн соёл гэдэг нь нэг нь нөгөөдөө багтах боловч хоёр өөр асуудал юм. Нийгэм хэдий чинээ улс төрийн соёлтой байна төдий чинээ улс төрийн систем зохион байгуулалттай байж, хамгийн боломжтой зөв сонголт явагдана. Улс төрийн соёл гэдэг бол 1956 онд Америкийн эрдэмтэн Г.Алмондийн тодорхойлсноор: Улс төрийн үйл явдалд хандах хувийн баримтлал, чиг баримжааны өвөрмөц хэв маяг⁴ гэж үзээд түүндээ хоёр янзын тодотгол хийсэн байдаг.

1. Улс төрийн соёл нь хэдийгээр соёл хэмээх ерөнхий ойлголтын бүрэлдэхүүн хэсэг боловч түүнийг нийт соёлтой адилтгаж болохгүй.
2. Улс төрийн соёл нь тухайн нийгэмд оршин тогтнож байгаа улс төрийн системтэй яг давхцаж түүгээр хязгаарлагдах албагүй гэж үзсэн байна.

Мөн Г.Алмонд, С.Верба нар хамтран улс төрийн соёлыг тодорхойлогч бие хүний хувийн чиг баримжааг дараах гурван түвшинд байна гэж үзжээ.

- Танин мэдэхүйн түвшин (улс төрийн системийн тухай мэдлэг сэтгэгдэл)
- Сэтгэл хөдлөлийн түвшин (улс төрийн системд хандах хандлага, мэдрэмж)
- Үнэлэх түвшин (улс төрийн объектуудын талаарх бодомж, сэтгэгдэл)

Үүнээс үзвэл бие хүний улс төрийн амьдралд оролцох оролцоогоор нийгмийн улс төрийн соёл тодорхойлгодоно. Улс төрийн систем бүрэлдэж тогтоогүй нийгэмд улс төрийн харилцаа ургалаар зохицуулагдаж, нийгмийн гишүүдийн чиг баримжаа нь шашны болон ёс суртахууны чиг баримжаанаас төдийлөн хэтрэхгүй байдаг онцлоготой.

Тоталитари дэглэмд нийгмийн гишүүд буюу бие хүн төр засаглалын зэрэг сэргийг үнэлэх чадвартай боловч улс төрийн амьдралд идэвхгүй, хэлбэрийн төдий оролцдог.

Ардчилал хөгжсөн оронд улс төрийн соёл олон янз байдалтай зэрэгцэн орших нь хэвийн үзэгдэл юм. Ийм нийгэмд улс төрийн соёлын идэвхтэй хэв маяг түгээмэл байдаг.

Нийгмийн улс төрийн соёл нь улс төрийн системийн бүтцэд нөлөөлөх бөгөөд энэ нь улс төрийн системийн зүгээс гарах шийдвэрийн хариу шаардлага, дэмжлэг ямар байх нь нийгмийн улс төрийн соёл, үүнээс хамаарсан системийн шийдвэрээр тодорхойлгодоно. Жишээ нь: нийгэм улс төрийн өндөр соёлтой бол улс төрийн системийн бүтэц зохион байгуулалт өндөр хэмжээнд байх бөгөөд шийдвэр өндөр түвшинд судлагдсан, амьдралд нийцтэй гарна. Харин нийгмийн улс төрийн соёл доогуур түвшинд буюу улс төрийн идэвхгүй бол сонголт алдаатай байх ба улс төрийн системийн бүтэц нь зохион байгуулалт муутай, хэрэв бүтэц механизм нь зөв сайн зохион байгуулагддаг ч гэсэн бүтэц дэх намууд буюу удирдах хэсгийнхэн алдаатай шийдвэр гаргахад хүргэдэг.

Улс төрийн намууд улс төрийн системийн бүтцэд нөлөөлөх нь: Аливаа улс төрийн намууд нь тухайн улс орон нийгмийг хөгжүүлэх өөрийн гэсэн бодлого хувилбартай байдаг бөгөөд түүнийгээ хэрэгжүүлэхийн тулд засгийн эрхийг авах туйлын зорилготой байдаг билээ. Чухам үүнийгээ хэрэгжүүлэхийн тулд төр барьж буй улс төрийн хүчнийг шүүмжлэх, олон түмнийг өөрийн үзэл баримтлалд итгүүлэх, уриалах, эрх баригч хүчний алдааг ашиглан олон түмнийг турхирах зэрэг янз бүрийн арга хэрэгслийг ашиглан сөрөг хүчин болон тэмцэх замаар улс төрийн системийн бүтцэд нөлөөлдөг.

⁴ Юндэндорж А., Атар Ю. Өрнө дорнын сэтгэгчдийн нийгэм улс төрийн онол, сургаал. Хөх хот, 2004, 609-610 дахь талууд.

Сонирхлын болон шахалтын бүлгүүд улс төрийн системийн бүтцэд нелөөлөх нь: Нийгмийн амьдралд эдийн засгийн, үндэсний, шашны, соёлын, экологийн, улс төрийн гэх мэт янз бүрийн сонирхлууд байдаг бөгөөд зөвхөн эдийн засгийн гэхэд л дотроо үй түмэн, хоорондоо зэрчилтэй ашиг сонирхлууд байдаг. Энэ бүх сонирхлууд нь нөгөөгөө хохигоохгүйгээр зохицуулагдана гэж байхгүй юм. Тийм учраас сонирхлыг нэгтгэх үйл явцыг улс төрийн намууд хийдэг. Улс төрийн намууд нэгтгэсэн сонирхлын үндсэн дээр сонирхлыг зохицуулах өөрийн үзэл баримтлалаараа сонирхогчийн дэмжлэгийг авч засгийн эрхийн төлөө тэмцдэг. Мөн иргэд улс төрийн бус сонирхлоо нэгтгэн олон нийтийн байгууллагыг байгуулдаг. Ийм сонирхлын бүлэг, олон нийтийн байгууллагууд нь сонирхлоо илэрхийлэх шаардлагыг улс төрийн системийн бүтцэд тавьдаг. Улс төрийн системээс гаргасан шийдвэрийг эсэргүүцэх, ашигтай шийдвэр гаргуулахыг шаарддаг бөгөөд энэ бүхнийг зохицуулж чадахгүй бол улс төрийн системийн бүтцэд нелөөлж өөрчлөлт ордог.

АНУ зэрэг гадаадын олон оронд үйлдвэрлэл, худалдааныхан болон нийгмийн бусад аль ч бүлэг өөртөө ашигтай шийдвэр гаргуулахын тулд тэр засаг, улс төрчдөд нелөөлөхийн тулд тусгай байгууллага ажилуулдаг бөгөөд түүнийг «лобби»* гэж нэрлэдэг. Лобби нь өөрийн ашиг сонирхлыг эдийн засаг, шинжлэх ухааны үндэстэй тайлбарлан итгүүлэх байдлаар нелөөлдөг бөгөөд ингэснээр ч бүтцийн өөрчлөлтийг ч хийж чаддаг. Гэтэл улс төрийн систем төлөвшөөгүй орнуудад лобби буюу шахалтын бүлэг нь хууль бус аргаар ажилладаг бөгөөд авилгал, бялуу хуваах, хуйвалдах, зөвшилцэх нэрийн дор улс үндэстний эрх ашгийг уландаа гишгэн наймаалцах гэх мэт нийгмийн эрх ашиг хөндөгдсөн шийдвэрүүдийг гаргадаг ба улс төрийн системийн бүтцэд ч өөрчлөлт оруулдаг.

Орон нутгийн удирдлага, байгаль, экологи, газар зүй нелөөлөх нь: Орон нутгийн удирдлага нь тухайн орон нутгийн засаг захиргааны харьяалал, экологийн байдал, байгалийн унаган төрх, хамгаалалтанд авах шаардлагатай газар, газар зүйн таатай ба таагүй орчин, нийгмийн амжиргааны түвшин дэх эдийн засгийн хөгжлийн урьдчилсан таамаглал зэрэг зүйлсүүдээр ард түмний хүсэлт, шаардлагыг улс төрийн системд өгч түүнийгээ биелүүлэхийн тулд тэмцлийн янз бүрийн хэлбэрийг ашиглан улс төрийн системийн бүтцийг өөрчлөхөд нелөөлж болдог. Энэ нь ялангуяа гүйцэтгэх засаглалын болон хууль тогтоох засаглалын ч бүтцэд өөрчлөлт оруулахад хүргэдэг байна.

Нийгмийн оюун санааны хямрал: Нийгэм нэг тогтолцооноос негеө тогтолцоонд шилжиж байгаа үед нийгмийн оюун санааг цэнэглэж байсан үзэл баримтлал, үнэт зүйлс үгүй болж тэр орон зайд нехөх үзэл баримтлал, үнэт зүйлсийн баримжаалал төлөвшөөгүй буюу бий болоогүй нехцөлд нийгмийн оюун санаа зөвхөн ахуйдаа захирагдан оюун санааны хямралд ордог. Нийгмийн философичид ахуй анхдагч, ухамсар анхдагч хэмээн маргалддаг боловч энэ нь харилцан диалектик зүй тогтолтой юм. Хүн идэхийн төлөө амьдрах уу?, Амьдрахын төлөө идэх үү?, Тэгвэл аль нь ч биш бөгөөд хүн ирээдүйдээ итгэх итгэл, хүсэл зорилгоор амьдардаг бөгөөд хүний адгууснаас ялгарах гол шинж энэ юм.

Нийгмийн оюун санаа хямралтай, ирээдүйдээ итгэх итгэлгүй, амьдралын хүсэл зорилго тодорхойгүй үед хүмүүст зөвхөн баяжих сонирхол давамгайлсан нехцөлд капитализмын гунигт алдааг давтах нь гарцаагүй юм. Зөвхөн хүмүүсийн хувийн ашиг сонирхол давамгайлсан нийгэм нь байнгын зөрчилдөөнөөр хөгжих бөгөөд жижиг улс үндэстний хувьд үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнол хэврэг байх нь аргагүй юм. Үндэсний бахархал, үндэсний ухамсар, үндэсний эх оронч үзэл, улс үндэстний эрх ашгийг тэргүүн зэрэгт тавьж, урьдах тогтолцооны

*Лобби. (англ. Lobby-хурлын гаднах тасалгаа). Улс төрийн хэллэгт парламентад нелөөлөх гэсэн утгаар хэрэглэддэг.

үнэт зүйлсээс хэрэгтэйг нь уламжлан авч үндэсний уламжлал ба шинэчлэлтэй холбон хөгжүүлбэл амжилтанд хүрэх нь зайлшгүй гэж үздэг.

Ном зүй

1. Современная политическая теория. М., 2001, с.209.
2. Философская энциклопедия. М., 1983, с.87
3. Малахов В.С., Филотова В.П. Современная западная философия. М., 1998, с.48
4. Юндэндорж А., Атар Ю. Өрнө дорнын мэргэдийн нийгэм-улс төрийн онол, сургаал. Дэд, гутгаар дэвтэр. Хөх хот, 2003, 103-105 дахь талууд.
5. Easton D. The Political sistem. N-Y., 1964, p.97.
6. Weinstein M. Sistematic Political Theory. Colunyus-Onio. 1971, p.12.